

“ХҮНС ХАНГАМЖ ТӨВ” ОНӨААТҮГ-ЫН 2018 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Хүнс Хангамж төв” ОНӨААТҮГ нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 206 дугаар тогтоолоор байгуулагдсан.

Тус газрын дүрмийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, шинэчилсэн дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлсэн.

Удирдлага: Б.Ичинхорол нь Нийслэлийн Засаг даргын 2017 оны Б/64 дүгээр захирамжаар захирлаар томилогдон ажиллаж байна.

Бүтэц орон тоо: Батлагдсан орон тоо 20, 2018 онд 19 ажилтантайгаар ажиллаж байна.

Агуулахын байршил: Сонгинохайрхан дүүргийн 2 дүгээр хороо, хуучнаар “Буянт манал” ӨЭМТ-ийн хуучин өөрийн байр

Одоогоор оффис Баянгол дүүргийн 20 дугаар хороо, Москвагийн гудамж, Фужи-Алтай барилгын 3 давхарт байрлаж байна.

Үндсэн үйл ажиллагаа: Сонгинохайрхан дүүргийн төрийн өмчийн цэцэрлэгүүдэд хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон илчлэг, шимт бодисын хэрэгцээ, хүнсний аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнийг захиалгын дагуу түргэн шуурхай ханган нийлүүлэх.

Хамрах хүрээ: Сонгинохайрхан дүүргийн 48 цэцэрлэг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Жаргалант тосгоны Хүн эмнэлэг, сургуулийн дотуур байрны нийт 14600 гаруй хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон хүнсний бүтээгдэхүүнийг захиалгын дагуу түргэн шуурхай ханган нийлүүлнэ.



Тус байгууллагын эзэмшилд Сонгинохайрхан дүүргийн 2 дугаар хорооны “буянт манал” ӨЭМТ-ийн эзэмшиж байсан барилга шилжиж ирсэн. Хуучин өрхийн эмнэлгийн барилга нь ашиглалтын шаардлага хангахгүй гэсэн мэргэжлийн хяналтын дүгнэлт гарсан тул шинээр барилга барих ажлын зураг төсөл боловсруулах ажлын саналыг зохих дээд шатны байгууллагуудад гаргаснаар шинэ барилгын зураг төслийн ажлыг “Алтан хөхийн очир” ХХК тендерт шалгарсны дагуу хийж гүйцэтгэн 1,3 тэрбум төгрөгийг 2019 оны төсөвт суулгахаар ажиллаж байна.

Хуучин барилга



Төлөвлөж буй зураг төсөл



Бодлогын зорилтын хүрээнд:

Байгууллагын үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах, ил тод байдлыг хангаж, мөнгөн хөрөнгө болон эд хөрөнгийг зохистой ашиглах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зэрэг манлайллын зорилтуудыг хангах талаар төсвийн шууд захирагчийн тухайн жилд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлох зорилгоор 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол, 2014 оны 157 тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагад дотоод хяналтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу “Дотоод хяналтын ажлын хэсэг” батлагдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаандаа хяналт тавин хяналт шалгалтын бүртгэл хөтөлж, ажлын үр дүн, гарсан зөрчил, дутагдлыг хэлэлцүүлэн шийдвэрлэж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Засгийн газрын тогтоол шийдвэр, тушаал, албан даалгавар үүргийн хэрэгжилт:

- **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 258 дугаар тогтоол**

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төрийн албан хаагчдын сахилга дэг журмыг чангатгах, ёс зүйн хэм хэмжээг сахиулж, хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор байгууллагын хэмжээнд шат дараалсан дараах ажлыг хийн ажиллаж байна.

1. Байгууллагын нийт ажилтан, албан хаагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн болон захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн 2 дугаар хэлтэстэй хамтран зохион байгуулж мэдээлэл, ухуулга, танилцуулга хийв.
2. Сонгинохайрхан дүүргийн 2-р хорооны нутаг дэвсгэрт байрлах өөрийн хүнсний агуулахын барилгад “Батлюкс” ХХК-тай хамтран камержуулалтын иж бүрэн төхөөрөмжийг суурилуулав.
3. Сонгинохайрхан дүүргийн 18-р хороо Авто 5 дугаар баазын байранд байрлаж байсан өөрийн оффисын барилгыг шинэчлэн Баянгол дүүргийн 20 дугаар хороо ФУЖИ Алтай барилгын 3 давхарт шилжин байршсан бөгөөд 24 цагийн харуул хамгаалалттай болно.
4. Албан хаагчдын ирцийн бүртгэлийг автоматжуулан хурууны хээ уншигч Attendance management программыг суурилуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Өмнө нь байрлаж байсан
оффисын барилга




Шилжин байршсан
оффисын барилга




Харуул
хамгаалалт



Өрөөний камержуулалт, хурууны хээ уншигч төхөөрөмж



Хүнсний агуулахын камержуулалт



Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоол, 2014 оны 157 тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагад дотоод хяналтыг зохион байгуулах нийтлэг журам”-д нийцүүлэн өөрийн байгууллагын дотоод хяналт, шалгалтын 2018 оны төлөвлөгөөг боловсруулан байгууллагын удирдлагаар батлуулж, мэргэжлийн боловсон хүчин бүхий дотоод хяналтын ажилтныг томилон ажиллуулж байна.

- **Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 36 дугаар тэмдэглэл**

Засгийн газрын “11-11” төв, Нийслэлийн “Call Center”, иргэдийн гаргасан өргөдөл хүсэлтийг шуурхай барагдуулах үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан “Цахим өргөдөл гомдлын программ” Smartcity.mn-д бүртгэгдсэн хүсэлт 14, **Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын систем “UBERP-д бүртгэгдсэн хүсэлт 4 байгаа бөгөөд 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар шийдвэрлэлт 100%-тай байна.**

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А/252 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн журам”-ын дагуу байгууллагын албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт, бүртгэл шилжүүлэг, шийдвэрлэлт, хяналт, тайлагналт, хэвлэмэл хуудасны захиалга, лавлах бүртгэлийн үйл ажиллагааг www.Edoc.ub.gov.mn домэйн нэр бүхий онлайн Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийг ашиглан ажиллаж байна.

- **“Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай**

Эрсдэлийн Удирдлага

MNS ISO 31000:2011



2018 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын Эрсдэлийн Удирдлагын багийн ахлагч доктор (Ph.D), дэд профессор Д.Түмэндэмбэрэл “Эрсдэлийн Удирдлага” сэдвээр “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын нийт ажилтан, албан хаагчдад танхимын сургалтыг хийлээ.

Энэхүү сургалтаар “Эрсдэлийн Удирдлага MNS ISO 31000:2011 Зарчим ба заавар “ стандартын танилцуулга, эрсдэлийн тухай ойлголт, учирч болох эрсдэл, түүнээс хэрхэн сэргийлэх болон байгууллагын үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалд нийцсэн зөвлөмж, зааварчилгаа өгч, нээлттэй санал солилцсон ажил хэрэгч, сонирхолтой сургалт болж өндөрлөлөө.



Хүнсний агуулахын шинэчилсэн самбар



Оффиссын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдээллийн самбар



“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалт

2018 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын улсын ахлах байцаагч Н.Одончимэг “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын нийт ажилтан, албан хаагчдад “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалтыг хийлээ.



Иргэдийн оролцоотой-Амьдрах орчныг сайжруулах жил

Иргэдийн оролцоотой-Амьдрах орчныг сайжруулах жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, нийслэлийн тохижилт, бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор өөрийн харилцагч 5 цэцэрлэгт элсний хаалттай саравчийг хийж гүйцэтгэн хүлээлгэж өглөө.

101 дүгээр цэцэрлэгийн тоглоомын талбайн нээлтийн үйл ажиллагаа



Сонгинохайрхан дүүргийн
101 -р цэцэрлэг



Сонгинохайрхан дүүргийн
91 -р цэцэрлэг



Сонгинохайрхан дүүргийн
163-р цэцэрлэг



Сонгинохайрхан дүүргийн
118-р цэцэрлэг



Сонгинохайрхан дүүргийн 79 дүгээр цэцэрлэг



“Мөнгөн хөрөнгийн нөөцийн зохистой ашиглах” хүрээнд:

Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу мөнгөн хөрөнгийг зарцуулж санхүүгийн тайлан тодруулгыг Санхүүгийн тайлагналын болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу гаргаж баталгаажуулав.

**Нийслэлийн Засаг Даргын хэрэгжүүлэгч агентлаг
Дотоод аудитын алба**

2018 оны 10-р сард Нийслэлийн Засаг Даргын хэрэгжүүлэгч агентлаг Дотоод аудитын албанаас Төсвийн тухай хуулийн 69.3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8.1.1, Засгийн газрын 483 тогтоолд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн дотоод аудитын албаны Санхүүгийн аудитын хэлтсийн ахлах аудитор Д.Нансалмаагаар ахлуулсан ажлын хэсэг манай байгууллагын 2017 он, 2018 оны 3

дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайлан, харилцах дансны баримт, бэлэн мөнгөний кассын баримт, хөрөнгө, материалын тайлангууд, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой баримтуудад шалгалт хийж 2017, 2018 онуудад Нийслэлийн Засаг Даргатай байгуулсан үр гэрээний үүргийг амжилттай хэрэгжүүлсэн, Нийслэлийн өмчийн харилцааны газартай байгуулсан контракт гэрээний үүргийг хэрэгжилтийг ханган ажилласан гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

Мөн 2018 онд худалдан авах ажиллагааг хуулийн дагуу явуулсан, байгууллагын ажиллагсдын цалинг нэмсэн, санхүүгийн үйл ажиллагаанд ахиц гарсан ололттой талуудыг дурдсан байна.

Их Монгол Хөлөг аудит ХХК

Их Монгол хөлөг аудит ХХК нь Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийж санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС, НББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” дүгнэлт гаргасан.

“Бует хөрөнгийн нөөцийг зохистой ашиглах” хүрээнд:

Бараа материалын тооллогыг долоо хоног бүр хийж, хариуцсан нярав, тооцооны нягтлан бодогчтой тулгаж, сар бүр агуулахын үлдэгдлийг баталгаажуулан ажиллаж байна. Түгээлтийн тээврийн хэрэгслийн ашиглалт, хамгаалалтад анхаарч, Засгийн газрын 2016 оны 213 дугаар тогтоолын дагуу тээврийн хэрэгслийн техникийн хяналтын ээлжит үзлэгт, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварт хамруулан, тухай бүр засвар үйлчилгээ хийж, явсан зам, шатахууны зарцуулалтыг тооцон жолооч нарт хяналт тавьж, тээврийн хэрэгслүүдийн аюулгүй байдлыг хангуулан ажиллаж байна.

“Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд:

“Няравын мэргэшүүлэх курс



Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын борлуулалтын нярав П.Равдансамбуу “Хөдөлмөрийн нөөц, санхүү менежментийн академи”-ийн нярав, компьютерийн хосолсон 14 хоногийн мэргэшүүлэх курсэд амжилттай суралцаж №2018/022 сертификаттай төгсөв.

Цахим систем ашиглалтын сургалт

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Худалдан авах ажиллагааны нэгдсэн системийг нийслэлийн хэмжээнд нэвтрүүлж, нутгийн захиргааны байгууллагуудын худалдан авах ажиллагааг 100 хувь /www.tender.gov.mn/ цахим системд нэгтгэх ажлыг хэрэгжүүлж, бүрэн ил тод, нээлттэй болгоно” гэж заасны дагуу 2018 оны худалдан авах үйл ажиллагааг байгууллага тус бүр цахим системээр зохион байгуулахыг уламжилсан.

Засгийн газрын 2017 оны 12 сарын 13-ны өдөр батлагдсан 337 дугаар тогтоолын 1.7.(в)-д “худалдан авах ажиллагааг цахимаар (tender.gov.mn) зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд оруулж нийтэд мэдээлж байх,” гэж заасан тул тус тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Худалдан авах ажиллагааны цахим систем” /www.tender.gov.mn/-ийн сургалтыг 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын байранд зохион байгуулагдаж сургалтад “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын захирал Б.Ичинхорол, ерөнхий нягтлан бодогч Н.Цэрэнбанзад, тооцооны нягтлан бодогч З.Мөнхшүр, Хүний нөөц, бичиг хэргийн ажилтан П.Хандсүрэн, хүнсний мэргэжилтэн Г.Оюундарь нар оролцов.

Сургалтын агуулга:

1. Цахим системийг Монгол улсын худалдан авах ажиллагааны салбарт нэвтрүүлсэн түүх;
2. Салбарын хөгжлийн хэтийн төлөв, хүлээлт болон зорилт
3. www.tender.gov.mn системийн давуу тал болон бүтэц, зохион байгуулалт;
4. Цахим систем ашиглан хэрхэн худалдан авах ажиллагааг зохион байгуулах

5. Худалдан авах ажиллагааг цаашид уламжлалт буюу цаасан хэлбэрээр зохион байгуулахгүй болсон талаарх чиглэл өгөх;
6. Бусад заавар зөвлөмжийг хүргэх



Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийг сайжруулах сургалт

Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийг сайжруулах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор шилэн дансны цахим системд мэдээллээ хэрхэн шивэх, анхаарах асуудлын талаарх сургалтыг 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 15 цагт Нийслэлийн Засаг захиргааны 5 дугаар “Иргэний танхим”-д зохион байгууллаа.

Сургалтад “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын ерөнхий нягтлан бодогч Н.Цэрэнбанзад, тооцооны нягтлан бодогч З.Мөнхшүр нар оролцов.

www.ublegal.mn цахим санг эрхлэн хөтлөх сургалт

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 90 дүгээр тогтоолоор “Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам”-ыг баталж, уг журамд нийцүүлэн www.ublegal.mn цахим санг эрхлэн хөтлөхтэй холбоотой мэдээлэл өгөх сургалтыг 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Хангарди ордны хурлын танхимд зохион байгуулдаж Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын хүний нөөц, бичиг хэргийн ажилтан П.Хандсүрэн хамрагдав.



Нийслэлийн Засаг Даргын хэрэгжүүлэгч агентлаг
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР
**Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын
систем “UBERP” сургагч багш бэлтгэх сургалт**

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

"Энэхүү төслийн зорилго нь мэдээллийн технологийн оновчтой шийдлийг ашиглан төрийн байгууллагуудын уламжлалт цаасан суурьт үйл ажиллагаанд **ДИГИТАЛ ШИЛЖИЛТ** хийх замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлэн, байгууллага нэгжүүдийн уялдаа холбоо, мэдээллийн урсгалыг сайжруулж, нэгдсэн удирдлагаар хангахад оршино"

Нийслэлийн Засаг Даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.4, 5.2.6, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5.17, 5.18 дахь заалт болон Нийслэлийн Засаг Даргын 2018 оны А/107 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудад хэрэглэгдэж буй программ хангамжуудыг холбосон нэгдсэн “UBERP” цогц системийг хөгжүүлэн, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад үе шаттайгаар нэвтрүүлэхээр анхны сургагч багш бэлтгэх сургалтыг 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж сургалтад “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын хүний нөөц, бичиг хэргийн ажилтан П.Хандсүрэн, тооцооны нягтлан бодогч З.Мөнхшүр нар оролцож “UBERP” дотоод удирдлагын системийн “Сургагч багш бэлтгэх” сургалтад амжилттай оролцож сургагч багшийн сертификатаа гардан авлаа.

Энэхүү систем нь ННЗБ-ын үйл ажиллагаа, албан хаагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн, инновацийг нэвтрүүлсэн, технологийн шинэ шийдэл бүхий нэгдсэн удирдлага хяналттай, уян хатан, цогц систем бөгөөд дараах үндсэн модультай. Үүнд:

- **Хүний нөөцийн удирдлагын модуль**

ERP систем болон түүнтэй холбогдон ажиллах бусад дэд системүүдийг хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн удирдлагаар хангах ба хүний нөөцтэй холбоотой бүх үйл ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэх, байгууллагын удирдлагыг бодит цаг хугацааны тайлан, мэдээллээр шуурхай хангах, оновчтой шийдвэр гаргалтыг дэмжих дэд систем юм.

- **Ажлын хэсэг, хурал, уулзалт, үүрэг даалгаврын модуль**

Ажлын хэсэг, хурал, уулзалт зохион байгуулах, үүрэг даалгавар бүртгэх, биелэлтийг тайлагнах үндсэн зориулалттай бөгөөд ажлын хэсгийн хурал, нийслэлийн удирдах албан хаагчдын шуурхай хуралдаан гэх мэт бүх төрлийн хурлыг зохион байгуулах, оролцогчдод хурлын товыг шуурхай хүргэх, үүрэг даалгавар үүсгэх, хариуцах байгууллага, албан хаагчдад хуваарилах, хурал уулзалтын тэмдэглэл, шийдвэрийг хөтөлж, бүх оролцогчдыг мэдээллээр хангаж, ажлын гүйцэтгэлийг бүртгэж, хяналт тавих боломжтой.

- **Олон нийтийн харилцааны модуль**

ННЗБ-ын албан хаагчдад албаны имэйл хаягаа холбон ашиглаж, байгууллагын дотоод сүлжээнд зурвас илгээх, хүлээн авах, файл дамжуулах, хуваалцах боломжтой.

- **Үндсэн хөрөнгө бүртгэлийн модуль**

Байгууллагын албан хаагчдын нэр дээр бүртгэх эд хөрөнгийн бүртгэлийг хүний нөөцийн системтэй уялдуулан холбож, үндсэн хөрөнгийн орлого, зарлага, хөдөлгөөний бүртгэлийг хөтлөх боломжтой.

- **Цаг бүртгэлийн модуль**

Байгууллагын онцлог, ажилтны цагийн хуваарь, хөдөлмөрийн гэрээний нөхцөл зэргээс хамаарч, бүтэн цагийн, хагас цагийн, ээлжийн, гэрээт ажлын цагийн хуваариар тохиргоо хийх, бүх төрлийн цаг бүртгэлийн төхөөрөмжтэй холбогдон ажиллах боломжуудтай бөгөөд байгууллагын удирдлага болон албан хаагчдын ирцийн тайлан, судалгааны бодит цаг хугацааны мэдээллээр хангах болно.

- **Өргөдөл гомдлын модуль**

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ННЗБ-уудад гаргах өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг өөрийн биеэр, өргөдөл бичгээр, гар утсаар, интернетээр дамжуулан авах бөгөөд үйлчлүүлэгч өөрийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн явцыг цахим хэлбэрээр бүрэн хянах боломжтой. Өргөдөл, санал, хүсэлтийг хүлээн авагч байгууллагууд тухайн хүсэлтийг нэгдсэн мэдээллийн санд оруулж, тодорхой шатны байгууллага мэргэжилтэнд шилжүүлж, хянан шийдвэрлэх зэрэг бүх үйл ажиллагааг энэхүү модульд цогцоор нь шийдвэрлэсэн.

- **Мэдэгдлийн системийн модуль**

Системийн хэрэглэгчид шинэ захидал, зурвас, сануулга, үүрэг даалгавар, хурал, уулзалт, ажлын хэсгийн мэдэгдэл ирсэн тухай болон системтэй холбогдон ажиллаж буй бусад системд ирсэн аливаа шинэ мэдээлэл, статус өөрчлөлтүүдийг мэдэгдэл, имэйл хэлбэрээр харуулж, хэрэглэгчид цаг алдалгүй мэдэгдэх боломжийг олгосон.

- **Үйл явдлын модуль**

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас дотоодын болон олон нийтийг хамарсан сургалт, тэмцээн, уралдаан, баярын арга хэмжээ гэх мэт үйл явдлыг төлөвлөх, мэдээлэл, зарлал үүсгэх, нийтлэх, хүргэх боломжтой.



Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа

Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол, 2014 оны 157 тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагад дотоод хяналтыг зохион байгуулах нийтлэг журам”-д нийцүүлэн өөрийн байгууллагын “Дотоод хяналтын журам”-ын дагуу дотоод хяналтын ажилтныг байгууллагын даргын удирдлаган дор зохион байгуулан жилийн ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд болон техникийн аюулгүй ажиллагаанд хийх хяналтын хүрээнд:

Машины эвдрэл гэмтэл, засвар үйлчилгээ хийж, агаарын бохирдол, АТБӨЯХАТатвар, автозам ашигласны төлбөрийг цаг тухайд нь төлж техникийн аюулгүй байдлыг хангаж ажиллуулсан. Машин техникийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг долоо хоног тутам шалгаж, шаардлагатай засвар үйлчилгээг тогтмол хийж ирсэн, Хүнсний бүтээгдэхүүнийг шаардлага хангасан нөхцөлд тээвэрлэхийн тулд машины чингэлгийн цэвэрлэгээг тогтмол хийлгэж хэвшсэн. Машины эвдрэл гэмтэлд засвар үйлчилгээг тухай бүрд хийж, техникийн аюулгүй байдлыг хангаж ажиллав.

Байгууллагын гадна орчны их цэвэрлэгээг пүрэв, баасан гарагуудад тогтмол хийж хэвшсэн. Ахуйн хортон шавж устгал, халдваргүйтгэлийн чиглэлээр хамтран ажиллах гэрээг “Цэвэр орчин ариусгал” ХХК-тай байгуулан гэрээний дагуу хортон шавж устгал, халдваргүйтгэлийг агуулахад хийлгэв.



2018-2019 оны хичээлийн жил эхлэхтэй холбогдуулан хүнсний агуулахад урсгал засварыг оруулан гадна талбайн тохижилт хийж засварлав.





Агуулахад чийг, дулаан хэмжигч байрлуулж, өдөр бүр хяналт тогтоож ажиллаж байна.

Гэрээт цэцэрлэгүүдэд нийлүүлж буй бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанарт тавих хяналт шалгалтаар:

Монгол улсын Шадар сайдын 2014 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 60 дугаар тушаалын дагуу Хилийн мэргэжлийн хяналтад хамрагдах их эрсдэлтэй импортын хүнсний бүтээгдэхүүнийг Улсын байцаагчийн дүгнэлттэй татан авч, биет үзлэгийн шалгалт хийн, хадгалалтын горимыг баримтлан нийлүүлж байна. Сүү, сүүн бүтээгдэхүүн, талх, талхан бүтээгдэхүүн зэрэг түргэн гэмтэх бүтээгдэхүүнийг захиалгын дагуу үйлдвэрээс нь шууд /итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүнг хавсарган/ түгээн ажиллаж байна.

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журмын дагуу 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдөр хүнсний ногоо нийлүүлж буй харилцагч байгууллага болох СХД-ийн 20 хооронд байрлалтай Эрдэнэ-Энх трейд” ХХК-ын хүнсний ногооны агуулах, хүнсний ногооны тариалан, хадгалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдалд хяналт, шалгалтыг хийлээ. Үүнд:

2017 оны хаврын тариалалтаар төмс 100 га, лууван 40 га, байцаа 15 га, шар манжин 5 га, хүрэн манжин 5 га, 0,3 га хүлэмжид өргөст хэмх тариалсан байна. Инженерийн байгууламж бүхий 1150га-д үр тариа, төмс хүнсний ногоо тариалж байгаагаас 130га газраар усалгаатай 2,5га -н хүлэмжид тариалалт хийж байна. Ногоог ачих тээвэрлэлтэд зориулагдсан портер, майти зэрэг тээврийн хэрэгсэлтэй. Хүнсний ногоог франц улсад үйлдвэрлэсэн яшигд хийн зориулалтын агуулахад 2000 тонн бүхий хүчин чадалтай зориулалтын агуулахтай.

Агуулахын зураг



“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын хүнсний ногооны бэлтгэн нийлүүлэгч “Эрдэнэ Энх трейд” ХХК-ын үйл ажиллагаатай танилцах үйл ажиллагаа

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын хамт олон 2018 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт байрладаг хүнсний ногоо бэлтгэн нийлүүлэгч, гэрээт байгууллага болох “Эрдэнэ Энх трейд” ХХК компанийн ногооны талбайд зочилж үйл ажиллагаатай нь танилцлаа.


Энэхүү арга хэмжээ нь ургац хураалт ид өрнөж буй энэ үед зохион байгуулагдаж тэдний бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах, тайлагнах, цаашид хийж хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн нэгдсэн мэдээллийг хүргэх гээд олон талын ач холбогдолтой болсон юм.

Тус компани нь тариалалтаас эхлээд хураах, тээвэрлэх, хадгалах, хэрэглэгчийн гарт очих хүртэлх бүхий л дамжлагыг стандартын дагуу явуулж эх орны хөрсөнд тарьж ургуулсан, чанар стандартын шаардлагыг хангасан органик бүтээгдэхүүнийг хэрэглэгч түмэндээ хүргэж буй үндэсний үйлдвэрлэгч тэргүүлэгч компанийн нэг юм.

Хүнсний ногооны тариалалт



Хүнсний ногооны хураалт, ялгалт, тээвэрлэлт





Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын хамт олон



Хөдөлмөрийн нөхцөл аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналтын хүрээнд:

Байгууллагын ажлын байранд тавигдах эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын шаардлага хангуулах, хөдөлмөрийн болон дотоод хяналт шалгалтын журам, ажлын хэсгийг шинэчлэн, төлөвлөгөөний дагуу ажиллаж, “Хүнсний тухай хууль”, Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль” болон холбогдох бусад хууль тогтоол, тушаалыг судлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын ажилчдыг ажилдаа гарах үед тухай бүр хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаар эрүүл ахуйч эмч зааварчилгаа өгөн ажилчдын ажил үүргээ гүйцэтгэх нөхцөлийг ханган, ажлын зориулалтын хувцас хэрэгслээр

болон түгээлтийн зориулалттай автомашин, хэмжих хэрэгслийн цэвэрлэгээ, эрүүл ахуйн шаардлагыг хангуулан ажиллаж байна.

Эрүүл мэндийн сайдын 212 дугаарт тушаалын дагуу байгууллагын нийт ажилтан, ажиллагсдыг 6 сар тутам эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж тогтмол хамруулан ажиллаж байна.

“Бидний эрүүл мэнд бидний аюулгүй байдал”




Хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэлтийн автомашинууд



Хүнсний бүтээгдэхүүний түгээлтийн автомашинууддаа шинэчлэл хийн Mitsubishi Canter, Nissan caravan машинуудыг шинээр худалдан авлаа.



Өөрийн үйл ажиллагаагаа өргөтгөн газар тариалан эрхлэх зорилгоор Төв аймгийн Борнуур сум Нарт /4-р баг/ Агьтын нутаг дэвсгэрт байрлах 25 га газрыг эзэмших гэрчилгээг байгууллагын нэр дээр гаргуулан авсан.



Ажилчдын хувцас, хэрэглэл 2018 он

Хуурай
бүтээгдэхүүн



Өдөр тутмын
хувцас



Ногооны хувцас



Махны хувцас



Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, “Мал амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам”-ыг үндэслэн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлт, дагалдах санхүүгийн баримтыг хавсарган эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг захиалгын дагуу бэлтгэн нийлүүлж байна.

ҮХАА-н сайдын 2013 оны А/98 тоот тушаалын дагуу “Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох” бүртгэлийн хуудас, “Урагш нэг шат” бүртгэлийн дэвтрийг хөтөлж ажилдаа хэрэгжүүлж байна. МХЕГ-ын даргын 2014 оны 156 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан Эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх зөвлөмжийн дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагаанд уялдуулан, Бичил цаг уур, Эрүүл мэнд ариун цэврийн, Мэргэжлийн сургалт, Хөргөх төхөөрөмжүүдийн “хэмийн”, Лабораторийн сорилтын дүнгийн, Их цэвэрлэгээ ариутгал, халдваргүйтгэлийн, Хортон шавж устгалын, Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний, Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах үйл ажиллагааг бүртгэх, мэдээлэх, Татан авсан хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийн талаарх мэдээлэл зэрэг бүртгэлүүдийг хөтөлж ажилдаа хэрэгжүүлж эхлээд байна. Долоо хоног бүр дотоод хяналт шалгалтын ажилтан нь хийсэн хяналт шалгалтын бүртгэл хөтөлж, өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай эрх зүйн /хууль, дүрэм, журам, стандарт гэх мэт/ мэдээллийн сан бүрдүүлэн, хяналт шалгалтын ажлын үр

дүн, авсан арга хэмжээний талаар илэрсэн зөрчил, дутагдлыг хэлэлцүүлэн шийдвэрлэж ажиллаж байна.

Санхүүгийн үйл ажиллагааны талаар:

Нэг: Үйл ажиллагаандаа хэрэгжүүлж буй хууль, тогтоомжийн талаар:

Санхүүгийн үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн заавар журам, Аудитын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Монгол улсын үндсэн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол улсын Төсвийн тухай хууль, “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”, “Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Нийслэлийн засаг дарга бөгөөд УБ хотын захирагчийн 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын хууль тогтоомж болон засгийн газар, Нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал түүний тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийн биелэлтийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Санхүүгийн тайланг улирал бүр “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргаж Нийслэлийн санхүү төрийн сангийн хэлтэст, Татварын тайланг улирал бүр гаргаж онлайнаар шивэн Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэст тус тус хүргүүлсэн.


Нийгмийн даатгалын тайланг сар бүр гаргаж, онлайнаар шивэн эх хувийг Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлж, ажилчдын нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн дэвтрийг баталгаажуулан ажиллаж ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал:

Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан Шилэн дансны тухай хуулийг дотооддоо хэрэгжүүлэн байгууллагын цахим хуудсанд цаг тухайд шинэчлэл хийж ажиллав.

Засгийн газрын 2017 оны 12 сарын 13-ны өдөр батлагдсан 337 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-с зарласан Сонгинохайрхан дүүргийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэгчийг сонгон

шалгаруулах 2018 тендерийг www.tender.gov.mn сайтад байршуулан худалдан авах үйл ажиллагааг цахимаар зохион байгуулан ажиллав.



Сонгинохайрхан дүүргийн төрийн өмчит цэцэрлэгүүдийн хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 2018/Б001 тендер шалгаруулалтад тэнцсэн:

Багц	Шалгарсан компани
Багц-05 хүнсний ногоо багц	“Эрдэнэ-Энх трейд”
Багц-06 нарийн ногоо багц	“Эрдэнэ-Энх трейд”

Сонгинохайрхан дүүргийн төрийн өмчит цэцэрлэгүүдийн хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 2018/Б002 тендер шалгаруулалтад тэнцсэн :

Багц	Шалгарсан компани
Багц-01 Хонины махны багц	“Хулагу холдинг” ХХК
Багц-02 Үхрийн махны багц	“Хулагу холдинг” ХХК
Багц-08 Жимсний чанамал шүүсний багц	“Эко-Эрдэнэ” ХХК
Багц-13 Бусад хүнсний бүтээгдэхүүний багц	“Баясах трейд” ХХК

компаниудтай “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29.1. “Захиалагч энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, бусад багцуудад шууд гэрээ байгуулахыг үнэлгээний хороо зөвлөж ажилласан.

Вэб сайт хөгжүүлэлт

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын ашиглаж байсан цахим хуудас орчин үеийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй мэдээ, мэдээлэл, дүрс, видео байршуулах боломжгүй зэрэг алдаатай хуудас байсан. Иймд цахим хуудсаа шинэчлэн дараах хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэлээ.

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын www.fsc.ub.gov.mn цахим хуудас	
Өмнө нь:	Дараа нь:
- Текст мэдээ байршуулахад алдаа гардаг. - Зурган болон дүрстэй мэдээ байршуулах талбар байхгүй. - Загвар хийц энгийн, хуучирсан, алдаатай. - Үндсэн болон дэд цэсүүдэд хөгжүүлэлт хийх шаардлагатай - Хандалтын тоо мэдээ буюу статистик мэдээ гардаггүй.	- Сайтад текст мэдээ байршуулахад программын алдаагүй болсон. - Зурган болон дүрстэй мэдээ байршуулах талбар нэмсэн. - Манай вэб хөгжүүлэлт HTML, CSS, JavaScript, AJAX, jQuery, XML based Technology зэрэг вэб програмчлалын технологиуд болон үндсэн дэвсгэр нь WordPress технологи дээр кодлогдсон. - Үндсэн цэсийг нэмэгдүүлж дэд цэсүүдэд хөгжүүлэлт хийсэн.

ISO 22000

“Монголоо тэвэрье”

2018 оны 05 дугаар сарын 09-ны өдөр Үндэсний шилдэг үйлдвэрлэгч “Талх Чихэр” ХК салбартаа анх удаа нэвтрүүлж буй “Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000 стандарт Монголоо тэвэрье” баярын үйл ажиллагаа болж “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын менежер Б.Мягмарсүрэн,

Ерөнхий нягтлан бодогч Н.Цэрэнбанзад, Хүнсний мэргэжилтэн Г.Оюундарь, Хүний нөөц, бичиг хэргийн ажилтан П.Хандсүрэн нар оролцлоо.

ISO 22000 стандарт нь хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сүлжээнд оролцож буй түүхий эд бэлтгэн нийлүүлэлтээс эхлэн хүнс үйлдвэрлэх, түгээх, хадгалах гээд хэрэглэгч хүртэлх бүхий л үйл ажиллагааг зохицуулдгаараа онцлогтой юм.

Ханган нийлүүлэгч 100 гаруй байгууллага хувь хүмүүсийн төлөөлөл энэхүү үйл ажиллагаанд хүрэлцэн ирсэн бөгөөд цаашдын хамтын ажиллагааны цар хүрээний талаар санал бодлоо хуваалцлаа.



“Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний систем” хэлэлцүүлэг



Нийслэлийн Засаг Даргын тамгын газар, Нийслэлийн Боловсролын газар, Шинжлэх Ухаан технологийн газартай хамтран Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч Ш.Анхмаагийн баталсан удирдамжийн дагуу сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг сайжруулах, стандарт шаардлагад нийцсэн сургуулийн өдрийн хоолоор үйлчлэхэд цаашид авах арга хэмжээний зөвлөмж

боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх зорилгоор “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний систем” сэдэвт хэлэлцүүлгийг 04 дүгээр сарын 25-ны өдөр Ерөнхий боловсролын 84 дүгээр сургууль дээр зохион байгуулагдлаа.

Тус хэлэлцүүлэгт “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын менежер Б.Мягмарсүрэн, хүнсний мэргэжилтэн Г.Оюундарь нар оролцож санал, бодлоо солилцлоо.

“Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт” хэлэлцүүлэг



2018 оны 4 дүгээр сарын 06-ны ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Худалдаа, нийтийн хоол, үйлчилгээний зохицуулалтын хэлтэс, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Худалдаа, нийтийн хоол, үйлчилгээний зохицуулалтын хэлтэс Монголын Махны Холбооноос “Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт” хэлэлцүүлгийг ХХААХҮЯ-ны хурлын бага танхимд зохион байгууллаа.

Тус хэлэлцүүлэгт Тус хэлэлцүүлэгт “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын менежер Б.Мягмарсүрэн, хүнсний мэргэжилтэн Г.Оюундарь нар оролцож дараах сэдвийн хүрээнд санал бодлоо солилцлоо. Үүнд:

- Мал төхөөрөх, мах ангилж савлах, мах боловсруулах үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага
- Мал, амьтан бэлтгэх, үйлдвэрт хүлээн авах, сойх, мал төхөөрөх үеийн мал эмнэлэг, эрүүл ахуй, технологийн шаардлага
- Мах, махан бүтээгдэхүүн худалдах үеийн эрүүл ахуйн шаардлага

Эрхлэгч нарын сургалт 2018

Хүнс хангмж төв ОНӨААТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын дагуу Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтэстэй хамтран ажиллагч төрийн өмчит цэцэрлэгүүдийн эрхлэгч нарт зориулан сургалтыг зохион байгуулан явууллаа.

Сургалтад 43 цэцэрлэгийн эрхлэгч нар хамрагдав.



“ ХҮҮХДИЙН ХООЛНЫ ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА, МОНГОЛ
УЛСАД МӨРДӨГДӨЖ БУЙ ДҮРЭМ ЖУРАМ” СЭДЭВТ
СУРГАЛТ”



**“ХҮҮХДИЙН ХООЛНЫ ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА,
МОНГОЛ УЛСАД МӨРДӨГДӨЖ БУЙ ДҮРЭМ ЖУРАМ”
СЭДЭВТ СУРГАЛТ**

2018.11.16



2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын ээлжит сургалт “ХҮҮХДИЙН ХООЛНЫ ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА, МОНГОЛ УЛСАД МӨРДӨГДӨЖ БУЙ ДҮРЭМ ЖУРАМ” нэртэйгээр зохион байгуулж сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын ахлах тогооч, нярав нарыг хамрууллаа.

Сургалтад Шинжлэх Ухаан Технологийн Их сургуулийн багш, доктор, профессор Б.Пүрэвжав “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны шим тэжээллэг байдлыг дээшлүүлэх нь” сэдвээр, “НЭМҮ төв”-ийн Хоол судлалын албаны цэцэрлэгийн хүүхдийн хоол шим тэжээлийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Оюундэлгэр “Боловсрол,Соёл шинжлэх ухаан спортын яам болон Эрүүл мэндийн яамны хамтарсан А448/268 тушаалын хэрэгжилт” сэдвээр, “НЭМҮ төв”-ийн Хоол судлалын албаны өсвөр үе эрүүл мэндийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Энхмягмар “Хүүхдийн хооллолтын олон улсын болон манай чиг хандлага” сэдвээр, Сонгинохайрхан дүүрэг дэх мэргэжлийн хяналтын хэлтсийн ахлах байцаагч Г.Батсүрэн “Сургууль цэцэрлэгийн орчинд зөвшөөрөгдөх хоол, хүнс болон хүнсний бараа бүтээгдэхүүнийг хэрхэн хадгалах” нь сэдвээр тус тус илтгэл тавьж харилцагч байгууллага болох “ТОМБАТ” ХХК бараа бүтээгдэхүүний танилцуулга хийж гарын бэлгээ гардууллаа.


Энэхүү сургалтыг Шинжлэх Ухаан Технологийн Их сургууль, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Хоол шим судлалын төв, Сонгинохайрхан дүүрэг дэх мэргэжлийн хяналтын хэлтэс зэрэг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан нь ахлах тогооч, нярав нарт чанартай, цэгцтэй мэдлэгийг өгч чадсанаараа онцлогтой юм.

НЭМҮ төв"-ийн Хоол судлалын албаны цэцэрлэгийн хүүхдийн хоол шим тэжээлийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Оюундэлгэр

“НЭМҮ төв”-ийн Хоол судлалын албаны өсвөр үе эрүүл мэндийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Энхмягмар



Сонгинохайрхан дүүрэг дэх мэргэжлийн хяналтын хэлтсийн ахлах байцаагч Г.Батсүрэн



Шинжлэх Ухаан Технологийн Их сургуулийн багш, доктор, профессор Б.Пүрэвжав



Намрын ногоон өдрүүд нэгдсэн арга хэмжээ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, үндэсний үйлдвэрлэгчид, тариаланчдын шилдэг бараа бүтээгдэхүүн, шинэ ургацын дээжийг хэрэглэгч түмэнд хүргэх, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн борлуулалтыг дэмжих зорилгоор “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” уриа дор “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээнд “Хүнс Хангамж төв” ОНӨААТҮГ 2018 оны 09 дүгээр сарын 23 өдөр Мишээл экспо төвд оролцов.



“Байгууллагын дотоод хяналт шалгалт хийх арга, зүй” сургалт

2018 оны 08 дугаар сарын 18–ны өдөр Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газраас зохион байгуулсан “Байгууллагын дотоод хяналт шалгалт хийх арга зүй” сэдэвт сургалтад “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын менежер Б.Мягмарсүрэн, хүнсний мэргэжилтэн нар оролцов.

Уг сургалтад Монгол Улсын Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор 2011 оны 11 дүгээр сарын 09-ны өдөр батлуулан мөрдөж эхэлсэн “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” болон дотоод хяналт шалгалтын хууль тогтоомж, стандартад нийцүүлэн байгууллагын зорилгыг хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг олж тогтоон, түүний шалтгааныг олж илрүүлэн, оновчтой шийдвэр гаргаж зөв чиглэл, урсгалд оруулах зорилготой юм.



226 -цэцэрлэгийн “Эерэг дадал-Эрүүл хүнс” сэдэвт хоолны өдөрлөг



04 дүгээр сарын 27-ны өдөр “Эерэг дадал-Эрүүл хүнс” сэдэвт хоолны өдөрлөг” зохион байгуулагдаж “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын ерөнхий нягтлан бодогч Н.Цэрэнбанзад, борлуулалтын нярав П.Равдансамбуу, хүнсний мэргэжилтэн Г.Оюундарь нар ооролцов.

112-р цэцэрлэгийн “Эрүүл зөв хооллолт” сэдэвт хоолны өдөрлөг



04 дүгээр сарын 14-ны өдөр 112-р цэцэрлэгийн “Эрүүл зөв хооллолт” сэдэвт хоолны өдөрлөг зохион байгуулагдаж борлуулалтын нярав М.Давхарбаяр, хүнсний мэргэжилтэн Г.Оюундарь нар оролцов.

214-р цэцэрлэгийн “Нээлттэй хаалганы өдөрлөг”



04 дүгээр сарын 13-ны өдөр “Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулагдаж борлуулалтын нярав М.Давхарбаяр, хүнсний мэргэжилтэн Г.Оюундарь нар ооролцоо.

“Цэцэрлэгийн хүүхдийн хоол, шим тэжээлийн байдлыг дээшлүүлэх боломж ба шийдэл” сэдэвт сургалт

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар , НҮБ-ын Хүүхдийн сан, Нийслэлийн Боловсролын газар, ШУТИС, Үйлдвэрлэлийн Технологийн газар, ШУТИС, Шим Тэжээл Судлалын төв хамтран цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулах, бага насны хүүхдийн хоол, хүнсний эрүүл, аюулгүй байдлыг дээшлүүлэх, тэнцвэртэй хоол ба давс, чихрийн агууламжийг бууруулах, 2018 оны 11 сарын 14 -ны “Цэцэрлэгийн хүүхдийн хоол, шим тэжээлийн байдлыг дээшлүүлэх боломж ба шийдэл” сэдэвт сургалтад Хүнсний мэргэжилтэн Г.Оюундарь хамрагдав.





“Цэцэрлэгийн хүүхдийн хоол, шим тэжээл-хоол үйлдвэрлэл, үйлчилгээний менежментийг сайжруулах төсөл”

KOICA – сангийн тэтгэлгээр СХД-ийн 117 цэцэрлэгт хэрэгжиж буй жишиг цэцэрлэг төслийн хүрээнд зохигдож буй семинар 2 буюу Улаанбаатар хотын цэцэрлэгийн хүүхдийн хоол, шим тэжээл-хоол үйлдвэрлэл, үйлчилгээний менежментийг сайжруулах төсөл 2018-2020 он сургалтад 2018 оны 12 дугаар сарын 18-нд Хүнсний мэргэжилтэн Г.Оюундарь хамрагдав.

Уг төслийн хүрээнд бага насны хүүхдийн хоол, шим тэжээлийн талаарх ойлголт болон хүүхдэд шим тэжээлийн боловсрол олгох аргуудын талаарх болон жишиг цэцэрлэгтэй танилцан туршлага судлалаа .





117 цэцэрлэгийн танилцуулга



Хоол үйлдвэрлэлийн хэсэг 1



Хоол үйлдвэрлэлийн хэсэг 2



Намрын өнгө “Ариун ургац амтат зоог” бидний нэг өдрийн зоог амталгаат өдөрлөгийн тайлан

2018.10.11.

СХД-ийн 111 –дугаар цэцэрлэг “Ариун ургац амтат зоог” өдөрлөгийг хамтран зохион байгуулан явуулав. Өдөрлөгийн арга хэмжээнд тус цэцэрлэгийн эрхлэгч СХД-ийн Иргэдийн төлөөлөгчид, “Хүнс Хангамж төв” ОНӨААТҮГ-ын Менежер Б.Мягмарсүрэн, Хүнсний мэргэжилтэн Г.Оюундарь мөн тус цэцэрлэгийн эцэг эхчүүд оролцсон.



“Ухаалаг монгол хүүхэд өдөрлөг”



2018.12.07-ны өдөр СХД-ийн 226 –дугаар цэцэрлэг “Ухаалаг монгол хүүхэд өдөрлөгийг хамтран зохион байгуулан явуулав. Өдөрлөгийн арга хэмжээнд тус цэцэрлэгийн Эрхлэгч, “Хүнс Хангамж төв” ОНӨААТҮГ-ын, Хүнсний мэргэжилтэн Г.Оюундарь, түгээлтийн нярав П.Равдансамбуу мөн тус цэцэрлэгийн эцэг эхчүүд оролцов.

БНСУ-д “Үдийн зоог” системтэй танилцах арга хэмжээ

2018.11.19-2019.11.23-ны хооронд Солонгос Улсын Боловсролын Шинжлэх Ухааны яам, Эрүүл мэндийн нэгдмэл сонирхол байгууллага /WITH/ болон Монгол Улсын Нийслэлийн боловсролын газрын дэмжлэгтэйгээр БНСУ-д “Үдийн зоог” системтэй танилцах арга хэмжээ зохион байгуулагдаж сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын хүнсний хангалтыг хариуцан ажилладаг байгууллагууд, албаны бусад хүмүүс оролцов.

Энэхүү арга хэмжээ нь Солонгос Улсын сургуулийн хоолны загвар үйлчилгээний менежмент, зохион байгуулалт, засгийн газрын бодлого, хууль тогтоомжууд, хоол хүнсний хүнс хангалтын систем зэргийг судлахад оршино.




Цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцав.





Сонгинохайрхан дүүргийн төрийн өмчит цэцэрлэгүүдээс авсан сэтгэл ханамжийн судалгааны тайлан

2018 оны 3-р улиралд авсан сэтгэл ханамжийн судалгаанд Сонгинохайрхан дүүргийн төрийн өмчит цэцэрлэгүүд, 74 дүгээр сургууль, Жаргалант тосгоны Хүн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэг зэрэг нийт 53 байгууллагын ахлах тогооч, нярав, эрхлэгч болон эцэг эхчүүд хамрагдаж, нар хамрагдаж, үйлчилгээний талаарх санал хүсэлт, сэтгэл ханамжийн судалгааг авч үнэлэлт дүгнэлт өгч ажиллалаа.



1. Манай байгууллагаас нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний нэр төрөл хангалттай эсэх

Нийт 53 байгууллагын ахлах тогооч, нярав нар хамрагдсанаас хангалттай эсэх-84,9 % буюу 45 цэцэрлэг, хангалтгүй - 15% буюу 8 цэцэрлэг санал хүсэлт илгээсэн.

2. Бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүйн байдлын талаарх үнэлэлт дүгнэлтээ өгнө үү

53 байгууллагын ахлах тогооч, нярав нар хамрагдсанаас хангалттай эсэх-88,6 % буюу 47 цэцэрлэг, 11,3 % буюу 6 цэцэрлэг хангалтгүй гэж үзсэн

3. Тус байгууллагаас нийлүүлж буй сүү, сүүн бүтээгдэхүүний нэр төрөл чанарт үнэлгээ өгнө үү .

Нийт 53 байгууллагаас Сүү сүүн бүтээгдэхүүн нийлүүлж буй байгууллага 47 байгууллагын 95,7% буюу 45 цэцэрлэг хангалттай , 6,3% буюу 2 цэцэрлэг хангалтгүй гэж үзсэн.

4. Тус байгууллагаас нийлүүлж буй махны чанар эрүүл ахуйн аюулгүй байдлын талаар үнэлгээ өгнө үү

Махны чанар эрүүл ахуйн аюулгүй байдал дээр 53 байгууллагаас хангалттай 92,4% буюу 49 цэцэрлэг , хангалтгүй эсэх 7,5% буюу 7 цэцэрлэг хамрагдсан.

5. Тус байгууллагаас нийлүүлж буй гурилан бүтээгдэхүүний нэр төрөл чанарт үнэлгээ өгнө үү

48 байгууллагад гурилан бүтээгдэхүүн нийлүүлдгээс 95,8% буюу 46 цэцэрлэг хангалттай , 4,1% буюу 2 цэцэрлэг хангалтгүй үнэлсэн.

6. Тус байгууллагаас нийлүүлж буй хүнсний ногооны чанар эрүүл ахуй аюулгүй байдлын талаар

сайн 73,5% буюу 39 цэцэрлэг, дундаж 9,4% буюу 5 цэцэрлэг , хангалтгүй 16,9% буюу 9 цэцэрлэг үнэлсэн.

7. Тус байгууллагын ажилтан албан хаагчидтай ойлголцоход хялбар байдаг эсэх

Судалгаанд хамрагдсан ахлах тогооч, нярав нар 95% саналаар ажилчдын харилцаа хандлага сайн, үйлчилгээ сайтай,

8. Тус байгууллагын түгээлтийн багийн зан харилцааны тал дээр үнэлэлт дүгнэлт өгнө үү

Сэтгэл ханамж 100% байгаагаа илэрхийлсэн байна.

9. Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн талаарх ойлголт авсан эсэх

Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн хуудас буюу Үйлдвэр Хөдөө Аж Ахуйн Сайдын А/98 дугаар тушаалаар сургалт хангалттай сургалт авч хэвшүүлсэн учир сэтгэл ханамж 71,6% буюу 38 цэцэрлэг , ойлголт муу 28,3% буюу 15 цэцэрлэг санал хүргүүлсэн.

10.Хүнсний бүтээгдэхүүний хадгалалт хамгаалалтын талаар ойлголт,мэдээлэл авч чадсан эсэх

100% буюу хадгалалт хамгаалалт ойлголт авч чадсан .

11.Захиалсан бараа бүтээгдэхүүн цаг хугацаандаа нийлүүлэгддэг эсэх

Захиалсан бараа бүтээгдэхүүнийг түргэн шуурхай цаг хугацаандаа нийлүүлж, сэтгэл ханамж 85% байгаагаа илэрхийлсэн байна.

12.Цахимаар захиалгаа өгөхөд үйл ажиллагаа түргэн шуурхай амар хялбар болж чадсан эсэх.

94,3% буюу 50 цэцэрлэг чадсан , 5,6 % буюу 3 цэцэрлэг хангалтгүй гэж үзсэн.


13.“Хүнс Хангамж Төв” ОНӨААТҮГ-с нийлүүлж буй бараа бүтээгдэхүүнийг хууль дүрэм журам стандартын дагуу буцаан татан авалт хийдэг эсэх.

Хууль дүрэм журам стандартын дагуу буцаан татан авалт 85% хийдэг.

“Мөнгөн Улаанбаатар” спорт наадам 2018

Монгол Улсын Биеийн тамир спортын тухай хууль, Засгийн газрын 2009 оны 05, 2017 оны 289 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2018 оны зорилтыг хэрэгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг Даргын 2018 оны А/23 дугаар захирамжийн дагуу “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын ажилтан, албан хаагчид 2018 оны 02 дугаар сарын 24-ны өдөр “Хандгайт”-ын Янзага зусланд “Мөнгөн Улаанбаатар” спортын наадмын “Цасны баяр” арга хэмжээнд идэвхтэй оролцлоо.

Нийт ажилчдыг биеийн тамир спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, амралт чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх ажлын хүрээнд байгууллагын спортын хамтлагийн үйл ажиллагааг сурталчилсан олон тэмцээн уралдааныг зохион байгууллаа.



Спорт өдөрлөг

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын хүнсний хангалтын хариуцан ажилладаг байгууллагуудын дунд уламжлал болгон зохион байгуулагддаг спортын өдөрлөг 2018 оны 05 дугаар сарын 26-ны өдөр болж өндөрлөлөө.

Өдөрлөгт “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ, “Асгат” ОНӨААТҮГ, “Багачууд хүнс” ОНӨААТҮГ, “Өсвөр үе” ОНӨААТҮГ 4 байгууллагын 90 гаруй тамирчид спортын 5 төрлөөр хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын ерөнхий нягтлан бодогч Н.Цэрэнбанзад шатрын төрөлд мөнгөн медаль, теннисийн төрөлд агуулахын нярав Д.Цэдмаа нар мөнгөн медаль авч менежер Б.Мягмарсүрэн гар бөмбөгийн шилдэг тамирчнаар шалгарлаа.



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРОО

“Үзэсгэлэнт Улаанбаатар цом” 2018

Дэлхийн автомашингүй өдрийг тохиолдуулан хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх, иргэнийг өвчлөлөөс сэргийлэх, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх боломжийг нэмэгдүүлэхтэй холбогдуулан Нийслэлийн Засаг Даргын 2018 оны А/861 дүгээр захирамжийн хүрээнд Нийслэлийн Засаг Даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг өртөөр марафон 2018 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр “Үзэсгэлэнт Улаанбаатар цом” нэртэйгээр зохион байгуулагдлаа.

Тус марафонд “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын ажилтан, албан хаагчдаас бүрдсэн холимог баг “Залуучууд” төрөлд амжилттай оролцлоо.



Бидний бүтээлч ажил

“Хаврын их цэвэрлэгээ”

ХҮНС ХАНГАМЖ ТӨВ ОНӨААТҮГ-ын нийт ажилчид 2018 оны 03 дугаар сарын 22-ны өдөр “ТАВ” ХК-ийн эзэмшлийн хашаан доторх 50 м2 талбайн ахуйн хог


хаягдал, хатсан өвс, шарилж хөл газрын ургамлыг цэвэрлэж хогийг цэгт хогийг тээвэрлэлээ.

ӨМНӨ НЬ

ДАРАА НЬ



ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ДАРАА



“Их цэвэрлэгээ-90 минут”

Нийслэлийн Засаг Даргын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/301 дүгээр захирамжийн дагуу Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас зохион

байгуулсан “Их цэвэрлэгээ-90 минут” бүх нийтийн цэвэрлэгээнд “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын ажилтан, албан хаагчид оролцлоо.

Их цэвэрлэгээний нэгдсэн нээлт 2018 оны 04 дүгээр сарын 21-ны Бямба гаригийн 11 цагт Сүхбаатарын талбайд болж хуваарийн дагуу Дунд голын ай сав, нийтийн эзэмшлийн гудамж талбайн хог хаягдлыг цэвэрлэн тээвэрлэж иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд өөрийн хувь нэмрийг орууллаа.

Хоггүй хотын төлөө ХАМТДАА



“Бүх нийтээр мод тарих өдөр” 2018

Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор 2018 оны намрын бүх нийтээр мод тарих өдрийг 10 дугаар сарын 13-нд тэмдэглэхтэй холбогдуулан “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын хамт олон өөрийн байрлаж буй Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт шар хуайс, голт борын 10 бутыг төв зам дагуу суулгаж цэнэг усалгааг хийлээ.





ДҮГНЭЛТ

“Хүнс-Хангамж төв” ОНӨААТҮГ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу тендер зарлаж шалгарсан аж ахуйн нэгж байгууллагуудаас чанарын шаардлага хангасан хүнсний түүхий эд бүтээгдэхүүн хүлээн авч Сонгинохайрхан дүүргийн төрийн өмчит цэцэрлэгүүдийг чанартай хүнсний бүтээгдэхүүнээр захиалгын дагуу тухай бүрд нь санал гомдолгүй ханган нийлүүлж, тайлангийн хугацаанд гадаад дотоодын сургалтад холбогдох ажилтан, албан хаагчдыг хамруулж, төлөвшүүлж мэргэшүүлснээр ажлын бүтээмж дээшилж Сонгинохайрхан дүүргийн сургуулийн өмнөх байгууллагад хоол хүнсээр дамжин халдварлах хоолны хордлого, хордлогот халдвар гаргаагүй, аюулгүй байдлыг хангуулж амжилттай ажиллаа.

Цэцэрлэгт нийлүүлж буй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын талаар сургалт өдөрлөг зохион байгуулан цэцэрлэгийн эрхлэгч нярав, тогооч, багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг эхийн зөвлөлүүдэд танилцуулан, санал хүсэлт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа хийж үнэлэлт дүгнэлт гаргаж, зөв зохистой хооллох дадал хэвшилд сургах арга зүйн мэдлэг өгснөөр хүнсний бүтээгдэхүүн хүлээн авахад тавигдах шаардлага, нярвын үйл ажиллагаа, хоолны технологи, цэсийн төлөвлөлт сайжирч байна.

Байгууллагын ололт амжилтыг бататган, хүнсний хангамжийн бүтээгдэхүүний нэр төрөл, чанарыг улам сайжруулах, соёлтой бөгөөд түргэн шуурхай үйлчилж цаашид хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах тал дээр анхаарч ажиллахаар төлөвлөж байна.

ХЯНАСАН:

ХҮНС ХАНГАМЖ ТӨВ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ

Б.ИЧИНХОРОЛ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХҮНИЙ НӨӨЦ, БИЧИГ

ХЭРГИЙН АЖИЛТАН:

П.ХАНДСҮРЭН